

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх



Түүнийг үргэлж дурсан сана

Моронай Мормоны Номын сүүлчийн үгсийг алтан ялтсууд дээр сийлэн бичиж байгааг та надтай хамт төсөөлөн бодно уу? Тэр ганцаархнаа байв. Тэр ард түмнийхээ болон өөрийн хүмүүсийн мөн гэр бүлийнхээ уналт, устгалыг харсан. Нутаг нь “цус урсгалтын талбар” болсон байсан (Мормон 8:8). Гэвч тэрээр бидний энэ үеийг харсан учраас түүнд найдвар төрж байв. Тэр юу ч гэж бичиж болох байсан ч гагцхүү биднийг *санагтун* хэмээн урьсан. (Моронай 10:3-ыг үзнэ үү).

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) толь бичиг доторх бүх үгнээс хамгийн чухал нь *санах* гэдэг үг юм хэмээн заах их дуртай байв. Бид Бурхантай гэрээ хийсэн учраас “хамгийн хэрэгтэй зүйл нь үүнийгээ санах явдал юм” гэж тэр хэлжээ.¹

Та *санах* гэдэг үгийг судруудаар нэг олж харж болно. Нифай ах нартаа сэрэмжлүүлэхдээ Их Эзэний үгсийг болон Бурхан өвөг дээдсийг нь хэрхэн хамгаалж ирснийг санахад үргэлж урьдаг байсан (1 Нифай 15:11, 25; 17:40-ийг үзнэ үү).

Хаан Бенжамин сүүлчийн агуу айлтгалдаа *санагтун* гэдэг үгийг 7 удаа давтан хэлсэн байдаг. Тэрээр “Бурханы агуу ихийг . . . түүний сайн сайхан хийгээд тэдэнд хандсан тэсвэрийг нь” өөрийнх нь хүмүүс санах болно гэдэгт итгэн найдаж байсан (Мозая 4:11; мөн 2:41; 4:28, 30; 5:11–12-ыг үзнэ үү).

Аврагч ариун ёслолыг тогтоохдоо шавь нараа Өөрийнх нь хийсэн золиослолыг “дурсаж” тэрхүү бэлгэдлээс хүртэхэд урьсан билээ. (Лук 22:19). Ариун ёслолын залбирал бүрд *сана* гэдэг үгийн өмнө *үргэлж* гэдэг үг байнга хэлэгддэгийг та бид сонсдог (С ба Г 20:77, 79-ийг үзнэ үү).

Миний захиас бол санахад урьсан урилга бөгөөд үүнийг бүр гуйлт ч гэж хэлж болно. Долоо хоног бүр ариун ёслолын нандин бэлгэдлээс хүртэхдээ таны санавал зохих 3 зүйлийг би дурдъя. Эдгээр нь надад тус болдгийн адил танд ч мөн тустай байгаасай гэж би найдаж байна.

Есүс Христийг дурсан сана

Нэгдүгээрт, Аврагчийг сана. Тэр энэ дэлхийд байхдаа хэн байсан болон бусадтай хэрхэн ярилцадаг байсныг мөн үйлдлээрээ нинжин сэтгэлээ хэрхэн харуулдаг байсныг сана. Тэр хэнтэй цагийг өнгөрүүлдэг мөн юу заадаг байсныг сана. Аврагч “сайныг үйлдэж явсан” (Үйлс 10:38). Тэр өвчтөнүүдийг эргэдэг байсан. Тэр Тэнгэрлэг Эцэгийн хүслийг гүйцэлдүүлэх үүрэгтэй байсан.

Юуны түрүүнд, бидний гэм нүглийн толбыг арилгахын тулд Аврагчийн төлсөн агуу төлөөс болон биднийг гэсэн Түүний хайрыг сана. Бид Аврагчаа санах тусам Түүнийг дагах бидний хүсэл өсөн нэмэгдэх болно. Бид арай илүү нинжин сэтгэлтэй, өршөөнгүй байж мөн

Бурханы хүслийг илүүтэй эрэлхийлж, гүйцэлдүүлэхээр хичээхийг эрмэлзэх болно.

Юуг илүү сайн хийх хэрэгтэй байгаагаа сана

Түүний цэвэр ариун, төгс байдлыг санахдаа өөрсдийн алдаа дутагдалтай төгс бус чанартай харьцуулахгүйгээр Аврагчийн тухай бодох нь хэцүү юм. Бид Түүний тушаалуудыг дуулгавартай дагах гэрээ хийсэн ч хааяа энэхүү өндөр жишигт хүрэлгүй унадаг. Гэвч Аврагч ийм зүйл болно гэдгийг мэдэж байсан учраас бидэнд ариун ёслолыг өгсөн юм.

Ариун ёслол нь Хуучин Гэрээн дэх нүглээ наманчлах гэх мэт золиослол хийх дадлагаас үндэслэлтэй (Левит 5:5-ыг үзнэ үү). Бид амьтдаар золиослол хийхээ больсон ч гэм нүглээ орхин хаяж чадна. Судруудад үүнийг “харууссан зүрх, гэмшсэн сэтгэл”-ийн золиослол гэж нэрлэдэг (3 Нифай 9:20). Ариун ёслолдоо наманчлах зүрх сэтгэлтэй ир (С ба Г 59:12; Моронай 6:2-ыг үзнэ үү). Ингэснээр та нүглийн өршөөлийг хүлээн авч, Бурхан руу хөтлөх замаас гарч төөрөхгүй байх болно.

Та өсөж хөгжиж байгаагаа сана

Ариун ёслолын үеэр та өөрийн амьдралыг үнэлж цэгнэхдээ бодол санаагаа зөвхөн хийсэн буруу зүйлс дээрээ биш; Тэнгэрлэг Эцэг, Аврагч хоёр өөрөөр тань бахархаж, сэтгэл хангалуун байгааг мэдэрч байсан тэр цаг үе болон зөв үйлдлүүд дээрээ төвлөрүүлдэг байх гэж би найдаж байна. Мөн та ариун ёслолын үеэр эдгээр зүйлийг олж харахад туслахыг Бурханаас гуйхад цаг гаргасан ч болно. Хэрэв та ийнхүү үйлдвэл ямар нэгэн зүйлийг мэдрэх болно гэдгийг би амлаж байна. Та итгэл найдварыг мэдэрнэ.

Намайг ийн үйлдэхэд, хэдийгээр би төгс төгөлдөрт хүрэхэд хол байгаа ч өчигдрийнхөөсөө өнөөдөр илүү сайжирсныг Сүнс надад батлан хэлж өгдөг. Аврагч байгаа болохоор энэ нь надад би маргааш илүү сайн болж чадна гэсэн итгэлийг төрүүлдэг юм.

Үргэлж гэдэг нь урт хугацаа учир ихээхэн анхаарал, хичээл зүтгэл шаарддаг. Байнга нэг зүйлийн тухай ухамсартайгаар бодох нь хэчнээн хэцүү болохыг та туршлагаасаа мэднэ. Гэсэн ч Их Эзэн Өөрийг нь үргэлж дурсан санах амлалтаа хэр сахиж байгаа гэдгээс тань үл хамааран таныг үргэлж санаж байдаг.

Аврагч танд тулгарч буй сорилт бэрхшээлийг мэднэ. Амьдралын санаа зовнилд дарагдах ямар байдгийг Тэр

мэддэг. Аврагчийг үргэлж дурсан санаж, дуулгавартай дагаснаар “[та] түүний Сүнсийг өөртэйгөө *үргэлж* хамт байлгах” адислал танд нэн хэрэгцээтэй байгааг Тэрээр мэднэ (С ба Г 20:77; тодотгол нэмэгдсэн).

Тиймээс Тэр таныг долоо хоног бүр ариун ёслолын ширээнд урьж, Өөрийг нь үргэлж дурсан санана гэдгийг дахин нэг удаа гэрчлэх боломжийг олгодог юм.

ТЭМДЭГЛЭЛ

1. Спэнсэр В.Кимбалл, “Covenants and Sacrifice” (Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандан хэлсэн үг, 1968 оны 6-р сарын 28), 5.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Завгүй амьдралын бужигнаан дунд бид Аврагч Есүс Христийг үргэлж дурсан санах нь амаргүй байдаг. Хэдий тийм ч, долоо хоног бүрийн ариун ёслол нь биднийг Түүний амьдрал, сургаалыг тунгаан бодох онцгой цаг хугацаагаар хангаж өгдөг. Одоо энэхүү нам гүм цагийг хэрхэн ашиглах, Аврагчид хэрхэн илүү сайн төвлөрч болох талаар гэрийн багшлалтаар очиж заадаг хүмүүстэйгээ хамт эргэцүүлэн бодож, ярилцаарай. Та хувийн зүгээс сайжруулж болох зүйлсээ эргэцүүлэн бодоход энэ цаг мөчийг хэрхэн ашиглаж болох вэ? Долоо хоног бүр өөрийн өсөж хөгжиж байгааг санаж байх нь хэр үнэ цэнтэй вэ?

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Санавал зохих гурван зүйл

Санах гэдэг үг Мормоны Номонд олон удаа гардаг. Бурхан өвөг дээдсийг нь хэрхэн харж, хамгаалж байсныг санаж байхад Нифай ах нараа урамшуулсан. Хаан Бенжамин Бурханы сүр жавхланг санаж байхыг өөрийн хүмүүсээс хүссэн. Мөн Моронай өөрийн уншигчдад Их Эзэн хэчнээн нигүүлсэнгүй болохыг сана хэмээн номлосон юм.

Аврагчийг дурсан санах нь зайлшгүй чухал бөгөөд бид ариун ёслолоос хүртэх бүрдээ Аврагчийг дурсан санах гэрээ хийдэг. Ерөнхийлөгч Айринг биднийг ариун ёслолын үеэр дараах гурван зүйлийг дурсан санахад урьдаг. Үүнд:

1. Есүс Христийг дурсан сана: Аврагч хэрхэн үйлчилж, бусдад хайраа хэрхэн үзүүлж байсан тухай судруудыг унш. Та Түүний хайрыг хэрхэн мэдэрдэг вэ? Та

Аврагчийн адилаар бусдад хайраа хэрхэн үзүүлж мөн үйлчилж болох вэ?

2. **Юуг илүү сайн хийх хэрэгтэй байгаагаа сана:** Та наманчлах зүрх сэтгэлээр өнгөрсөн долоо хоногийнхоо талаар тунгаан бод. Та өөрчилж болох нэг зүйлийг сонгоод, энэ өөрчлөлтийг хэрхэн хийх тухайгаа бич. Зорилгоо үргэлж харж байх газарт тавь.
3. **Та өсөж хөгжиж байгаагаа сана:** Өөрийнхөө гаргаж байгаа сайн өсөлт дэвшлийг олж харахад туслахыг Бурханаас гуй. Юу мэдэрч байгаагаа тэмдэглэ.

Бид төгс бус ч үүнийг Аврагч маань мэддэг. Тийм болохоор Тэр биднээс Өөрийг нь дурсан санаж байхыг хүсдэг юм. Түүнийг санан дурсах нь бидэнд найдвар төрүүлж, сайжрах хүсэлтэй болоход тусалдаг. Тэр ч бүү

хэл, Түүнийг санахаа мартсан үед ч “Тэр биднийг үргэлж санаж байдаг” хэмээн ерөнхийлөгч Айринг хэлсэн.

“Их Эзэн хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар сана” (Моронай10:3).

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүсийг дурсан санах нь

Судрууд бидэнд Есүс Христийг үргэлж дурсан санах хэрэгтэй гэж заадаг. Энэ нь бид Түүний тухай маш их тунгаан бодож мөн үлгэр жишээг нь дагана гэсэн үг!

Есүсийн зургийг байнга харж байх газарт байрлуул.

“Мөн хэрэв та нар намайг үргэлж санах аваас миний Сүнс та нартай хамт байх болно” (3 Нифай 18:7).



Тэр эгчийн тухай болон гэр бүлийнх нь талаар мэдэж ав

Бид айлчлагч багшаар явснаар эгч бүртэй чин сэтгэлээсээ дотно танилцаж, тэднийг хайрлах болж, улмаар итгэлээ бэхжүүлэхэд нь тусалж, үйлчлэл үзүүлдэг.

Итгэл, гэр бүл, халамж

Рита Жэппэсон айлчлагч багштайгаа уулзаж, тэд сайн мэдээний зарчмуудаас хуваалцсанаар сайн найзууд болжээ. Мөн тэд уулзахдаа үгээр наадах тоглоом тоглодог аж. Ритад айлчлагч багшийнх нь энэ чанар хамгийн их таалагддаг. Учир нь тэр түүнтэй найзууд гэдгээ мэддэг бөгөөд зөвхөн бүртгэлд “тэмдэглүүлэх” гэж айлчилдаггүй гэдгийг ч бас мэддэг. Эгч нар айлчилж очих үеэрээ хамтдаа алхах эсвэл хүүхдүүдийг нь тоглож байх хооронд цэцэрлэгийнх нь зэрлэгээс зулгаалцах гэх мэт олон зүйл хийж болно.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд: “Өөрсдийгөө Их Эзэний хүүхдүүд рүүгээ илгээсэн төлөөлөгч хэмээн . . . харна уу. Бид та бүхнийг гишүүдэд сайн мэдээ рүү чиглэсэн анхаарал халамжийг чин сэтгэлээсээ тавьж, бие биенээ өрөвч энэрэнгүй сэтгэлээр харж хандан, сүнслэг болон материаллаг хэрэгцээг нь

боломжтой бүхий л аргаар чадах чинээгээрээ тусалж, шийдвэрлэдэг тийм цаг үеийг авчирна байх гэж найдаж байна”¹ гэж хэлсэн.

Их Эзэн Израилийн хүүхдүүдэд Мосегоор дамжуулан “Та нартай хамт амьдрах харийн хүн нь та нарт, дунд чинь буй уугуул хүн мэт байх ёстой” (Левит 19:34) хэмээн зарлиглажээ. Биднийг үйлчлэлээ эхэлж байх үед айлчилж очдог эгч нар маань “танихгүй хүн” байж болох ч, харин бид түүнийг болон гэр бүлийг нь таньж мэддэг болсноор “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд үүрэлцэх” мөн “зүрх сэтгэлээ эв нэгдэл хийгээд нэг нэгнийхээ зүгт хандсан хайранд нэгтгэх” бидний хүсэл өсөн нэмэгдэх болно (Мозая 18:8, 21).

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Рэйна И.Абурто эгч нөхрөөсөө салсны дараахан Сүмийн шинэхэн гишүүн байсан үеийнхээ талаар:

“Айлчлагч багш нар маань манайд ирж, надад маш дотно, дулаан мэдрэмж төрүүлж, зүрх сэтгэлд минь хайрыг авчирч билээ”² гэж дурсан ярьж билээ.

Үүнийг эргэцүүлэн бод

Та айлчлан очдог эгч нарынхаа гэр бүлийнхэнд хамааралтай ямар үйл ажиллагаа болох гэж байгааг мэдэж авах мөн санаж байх хэрэгтэй юү?

ЭШЛЭЛҮҮД

1. Жэффри Р.Холланд, “Сүмийн төлөөлөгчид,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган.
2. Рэйна И.Абурто, “What Has Relief Society Been for Me?” Бригам Янгийн Их Сургуулийн эмэгтэйчүүдийн чуулган дээр хэлсэн үгнээс, 2017 оны 5-р сарын 5, LDS.org

Тохинуулах нь

Бид айлчлан очдог эгч бүрээ болон тэдний гэр бүлийг таньж мэддэг болж, хайрлах юм бол хүн бүрийн материаллаг болоод сүнслэг хэрэгцээнд хэрхэн тусламж үзүүлэхээ олж мэдэх хувийн илчлэлтийг хүлээн авах болно.